## АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

## АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны 11 дүгээр сарын 15 Арвайхээр

| Д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэл-тийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 5 | 7 | 8 |
| Зорилт нэг.Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | | | | | | | |
| 1 | 1.1.Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн шторк инфографик, нийтлэл, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг боломжит бүхий л сувгаар олон нийтэд хүргэх | Мэдээлэл дамжуулсан сувгийн тоо | Цахим хуудас-5, хэвлэл мэдээллийн байгууллага-3, самбар-1 | Цахим хуудас-13, хэвлэл мэдээллийн байгууллага -5, самбар-2 | “Arvaikheer.uv.gov.mn” албан ёсны вэбсайтын “Ил тод” цэсийн Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа дэд цэсэд урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх цэсэд Авлигатай тэмцэх газрын олон нийтийн төв цахим хуудсыг холбож, тв шторк, инфографик, видео график, нийтлэл, зурагт хуудас зэрэг авлигын эсрэг сурталчилгааны материалыг иргэдэд хүргэх эх үүсвэрийг нэмэгдүүлсэн. Мөн дээрх сурталчилгааны материалуудыг “Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газар” цахим хуудас, Өвөрхангай аймгийн олон дагагчтай цахим группүүд, 13 багийн цахим хуудас, групп, байгууллагын “Авлигагүй бүс”, “Ил тод” мэдээллийн самбараар дамжуулан иргэдэд хүргэж байна. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хэвлэл мэдээллийн 8 байгууллагатай хамтран ажиллах гэрээг байгуулж, АТГ-аас бэлтгэсэн сурталчилгааны материалыг цахим орчин болон телевизийн эфирээр түгээсэн. | 01-11 сар | 100 |
| 2 | 1.2.Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийг нээлттэй ил тод иргэдэд хүргэх | Зохион байгуулсан арга хэмжээний тоогоор | 2 | 3 | Арвайхээр сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2025.01.02-ны өдөр батлуулсан. Төсөл арга хэмжээний мэдээллийг https://shilendans.gov.mn/ organization/https://arvaikheer.uv.gov.mn/ пейж хуудасны Шилэн төсөв цэс, Засгийн газрын https://shilen.gov.mn/ сайтуудад холбоос хийж, байгууллагын “Ил тод” самбарт байрлуулж иргэдэд мэдээллийг ил тод хүргэж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтыг 100 хувь цахимаар зохион | 01-11 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулсан. Төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажлуудад тухайн багийн ажлын алба, иргэний хяналтын зөвлөл явцын хяналтыг хийж, хүлээн авах ажлын хэсэгт тухайн багийн Засаг даргыг ажиллуулж хэвшсэн. | | |
| 3 | 1.3.Байгууллагын Ил тодын самбарт Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" булан ажиллуулах. | Шинэчилсэн мэдээллийн тоогоор | 8 удаа | 10 удаа | Байгууллагын "Авлигагүй бүс" самбарын мэдээллийг сар бүр шинэчлэн байршуулж, авлигын хэлбэрүүдийн талаар, 110 дугаартай утас түүний дэлгэрэнгүй мэдээлэл болон Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн мэдээлэл, сурталчилгааны зурагт хуудас, постерийг тухай бүр байршуулж байна. Тайлант хугацаанд самбарын мэдээллийг 4 удаа бүрэн, 6 удаа хэсэгчлэн шинэчилсэн. | 01-11 сар | 100 |
| 4 | 1.4.Авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах, хамтарч ажиллах | Хамтарч ажилласан байгууллагын тоогоор | 2 | 3 | Орон нутгийн хэвлэл мэдээллийн 8 байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан мэдээ, мэдээллийг иргэдэд түгээн, гэрээнд заасны дагуу авлигын эсрэг 4 контентыг бүтээж иргэдэд хүргэсэн. Хүний эрхийн үндэсний комиссын Өвөрхангай аймаг дахь референт, Төгс амьдралд тэмүүлэхүй ТББ-тай хамтран ажиллаж, хүний эрх, эрх чөлөө, тэгш боломжийн талаар иргэд, ахлах ангийн сурагчдад сургалт зохион байгуулж, нийт 370 суралцагч болон тэдний асран хамгаалагч хамрагдсан. Ерөнхий боловсролын 1, 4 дүгээр сургуулиудтай хамтран ахлах ангийн сурагчдын дунд "Авлига ба бидний ирээдүй" хэлэлцүүлэг зохион байгуулж 25 сурагч оролцсон. | 01-11 сар | 100 |
| Зорилт 2.Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох | | | | | | | |
| 5 | 2.1.Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх. | Байгуулсан гэрээний тоогоор | - | Тухай бүр | Хуулийн этгээд, хувь хүнтэй байгуулж байгаа гэрээний тусгай нөхцөлийн хэсэгт "Авлига, ашиг сонирхлын шинжтэй үйлдэл, мэдээлэл илэрсэн бол гэрээг цуцлах үндэслэл болно" заалтыг гэрээнд заавал тусгах чиглэлийг мэргэжилтнүүдэд өгч, улс орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх нийт 27 гэрээнд гэрээнд тусган хэрэгжилтэд хяналт тавьсан. | 1-11 сар | 100 |
| 6 | 2.2."Төрийн | Хэрэгжилтийн | - | 90,0 дээш | Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, | 01-11 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх. | хувиар | | хувиар | авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилт, шилэн дансны хөтлөлт, нийтэд ил байхаар хуульд заасан мэдээллүүдийг arvaikheer.uv.gov.mn сайтын "Ил тод" цэс, Shilen.gov.mn сайтад ил тод байршуулж, иргэдийн мэдээлэл авах эрхийг хангаж ажиллаж байна. Төсвийн тухай хуульд заасны дагуу тухайн жилийн төсвийн гүйцэтгэл болон ирэх оны төсвийн төслийг ИТХ-аар хэлэлцүүлэхдээ хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдийн төлөөллийг оролцуулж хэвшсэн. Худалдан авах ажиллагааны Төсөл арга хэмжээний мэдээллийг https://shilendans.gov.mn/organization/-д, https://arvaikheer.uv.gov.mn/, Шилэн төсөв цэс, https://shilen.gov.mn/ сайтуудад байршуулсан. Урт, дунд хугацааны бодлогын баримт бичиг боловсруулах, захиргааны ерөнхий хуульд заасан шийдвэр гаргахдаа иргэдийн оролцоог хангаж саналыг цахим, болон цаасан хэлбэрээр авч бодлогын баримт бичигт тусган хэрэгжүүлж байна. 2025 онд хүнс барааны төв захын амрах өдөр тогтоох, Өвөрхангай аймгийн 2026-2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл (772), Цэвэр агаар хөтөлбөрт тусгах санал (514) -ыг иргэнээс авч, эрэмбэлэн бодлогын баримт бичигт тусгасан. | сар | |
| Зорилт 3.Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах | | | | | | | |
| 7 | 3.1.Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх. | Зөрчигдсөн хуулийн заалтын тоогоор | 0 | 0 | Ажлын байрны сул орон тооны зарыг Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлж, Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам"-д заасны дагуу төрийн албаны тусгай шалгалт өгч, хамгийн өндөр авсан иргэдийг тухайн албан тушаалд нэр дэвшүүлсэн Төрийн албаны салбар зөвлөлийн тогтоолыг үндэслэн тайлант хугацаанд хууль эрх зүй хариуцсан мэргэжилтнийг томилсон. Томилготой холбоотой гомдол мэдээлэл бүртгэгдээгүй байна. | 01-11 сар | 100 |
| 8 | 3.2.Төрийн албаны салбар зөвлөлийн | Дүгнэлтийн тоогоор | 9 | Тухай бүр | Арвайхээр хотын захирагчийн албаны ерөнхий менежер, Согоот 1 дүгээр багийн Засаг дарга, Хүйс | 01-11 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг тухай бүрд олон нийтэд ил тод болгох. | | | | толгой 11 дүгээр багийн Засаг дарга, Бурхи 9 дүгээр багийн Засаг даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэхээр нэр дэвшсэн иргэдийн хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хянуулж, дүгнэлтийг үндэслэн томилсон. (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг https://arvaikheer.uv.gov.mn/ пейж хуудсанд байршуулсан. | | |
| 9 | 3.3.Байгууллагын дотоод хяналт шалгалтын нэгжийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, гүйцэтгэлд хяналт тавих | Хийсэн хяналт, шалгалтын тоогоор | 1 | 3 | Байгууллагын дотоод хяналт шалгалтын нэгжийн 2025 онд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. Батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн хүрээнд Албан хаагчдын техник хэрэгслийн ашиглалт, хадгалалт хамгаалалтад, Байгууллагын дотоод журмын хэрэгжилтэд, Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагаанд, Албан хаагчдын албан хэрэг хөтлөлтөд дотоод хяналт шалгалт хийж, тайланг илтгэх хуудсаар байгууллагын удирдлагуудад танилцуулсан. | 01-11 сар | 100 |
| 10 | 3.4.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх | Цахим хэлбэрт шилжүүлсэн үйлчилгээний тоо | 9 | 9 | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал e-mongolia.mn системд Засаг даргын Тамгын газрын 9 үйлчилгээ нэвтэрч иргэдэд үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Иргэд өөрийн оршин суугаа хаягийн тодорхойлолт, ажилласан жилийн лавлагаа, орц гарц гаргах зөвшөөрөл авахад Е-Монголиа системд хандаж зөвшөөрөл авах боломжийг байгууллагын цахим хуудсаар сурталчлан, мэдээлэл байршуулж байна. 2025 оны эхний 11 сарын байдлаар 360 иргэний хүсэлт ирсэн байна. Үүнээс 343 иргэний хүсэлтэд хариу өгч шийдвэрлэсэн бөгөөд хаягийн зөрүүтэй 303 хүсэлтэд татгалзаж, 40 иргэний хүсэлтэд зөвшөөрсөн байна. | 01-11 сар | 95,2 |
| Хэрэгжилт-98,5 | | | | | | | |

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА С.ГАНЧИМЭГ

1024010060 9044132 СВТ24591